

**“ШИВЭЭ ОВОО” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2016 оны 04 дүгээр  
сарын 28-ний өдөр

Дугаар **06**

Уланбаатар хот

Компанийн дүрэмд нэмэлт  
өөрчлөлт оруулах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, “Шивээ Овоо” ХК-ийн дурмийн 10.10.1 заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. “Шивээ Овоо” ХК-ийн дүрэмд оруулах нэмэлт, өөрчлөлтийг хавсралтаар баталсугай.

Хоёр. Дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулж бүртгэлийн байгууллагаар баталгаажуулахыг компанийн төлөөлөн удирдах зөвлөл болон Гүйцэтгэх захиралд үүрэг болгосугай.


ХУРЛЫН ДАРГА



Б.АРИУНБОЛД

Хувьцаа эзэмшигчдийн 2016 оны 04 сарын 28-ны  
өдрийн 06 дугаар тогтоолын хавсралт

**"ШИВЭЭ ОВОО" ХК-ИЙН ДУРМИЙН,  
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ**



1. "Шивээ Овоо" ХК-ийн дурмийн 12 дугаар зүйлийн 12.1-д "Компанийн териин мэдлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг толгой компанийн төлөөлөн удирдах зөвлөлөөс эрх олгосон эрх бухий албан тушаалтан болон толгой компанийн гүйцэтгэх захирал хамтран хэрэгжүүлнэ. Толгой компанийн төлөөлөн удирдах зөвлөлөөс эрх олгосон этгээд болон толгой компанийн гүйцэтгэх удирдлага нь хувьцаа эзэмшигчийг төлөөлөх эрхээс хэрэгжүүлэхдээс толгой компанийн төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан удирдамжийг баримтлах багаад энэхүү удирдамжаас өөр санал гаргасан нь түүнийг энэхүү төлөөллийг хэрэгжүүлэх эрхээс чөлөөлөх үндэслэл болно. Гэж заасныг "12.1. Компанийн териин мэдлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг толгой компанийн гүйцэтгэх захирал хэрэгжүүлнэ. Териин мэдлийн хувьцааны эрхийг хэрэгжүүлэгч нь Толгой компанийн гүйцэтгэх удирдлагийн удирдамжаас өөр санал гаргасан нь түүнийг энэхүү төлөөллийг хэрэгжүүлэх эрхээс чөлөөлөх үндэслэл болно." гэж өөрчилсүгэй.

2. "Шивээ Овоо" ХК-ийн дурмийн 12 дугаар зүйлийн 12.6.7-д Териин мэдлийн хувьцаанд ногдох хувьцааны ногдол ашгийг зөвхөн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн шийдвэрийг харгалзан Компанийн тухай хуульд заасны дагуу хувьцаа эзэмшик буй этгээдийн дансанд шилжүүлнэ гэж оруулах.

3. "Шивээ Овоо" ХК-ийн дурмийн 17 дугаар зүйлийн 17.2.-т "Компани нь "Нягтлан бодох бүртгэлийн тухай" хууль, "Аудитын тухай" хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу nyaгтлан бодох бүртгэлээ хөтлөн санхүүгийн тайлан гаргаж татварын байгууллага, Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн бирж болон хуулиар заагдсан бусад байгууллагуудад хугацаанд нь хургуулна." гэж заасныг "Компани нь "Санхүүгийн тайллагналын олон улсын стандарт" (СТОУС), "Олон улсын nyaгтлан бодох бүртгэлийн стандарт" (ОУНББС), "Нягтлан бодох бүртгэлийн тухай" хууль, "Аудитын тухай" хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу nyaгтлан бодох бүртгэлээ хөтлөн санхүүгийн тайлан гаргаж татварын байгууллага, Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн бирж болон хуулиар заагдсан бусад байгууллагуудад хугацаанд нь хургуулна." гэж өөрчлөх

--оо--